



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/516

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2. 2 дахь заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Шимт ганга, Вансэмбэрүү I, Галтай мянган, Хос Алтайн тун эмийн сангуудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр тус тус сунгасугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг хангасан нь Эрүүл мэндийн газрын ажлын байрны дүгнэлт гаргах комиссын саналаар зөвшөөрөгдсөн дотор, эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Мөнгөн морьт" хувийн эмнэлэг, мэс засал, гэмтэл, дотор, уламжлал, хавдар, лаборатори, дүрс оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Ач заяа" эмнэлэгүүдэд тус тус өдрийн эмчилгээний, дотор, лабораторын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Мөнхцохилохуй" эмнэлэгт уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсугай.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө сунгуулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Zan A/516 Kh